



ADRA



Alpha Mongols

NextGen CELEBRATIONS! Mongolia

СОНИНГИЙН ДУГААР №1
2023 ОН 10 ДУГААР САР

ТОВХИМЛЫН АГУУЛГА

- Альфа үеийнхэн Монгол төсөл гэж юу вэ
- Мэндчилгээ
- Төслийн зорилго
- Хүлээгдэж буй үр дүн
- Төслийн тогтвортой байдал
- Төслийн онцлох үйл ажиллагаа
- Төслийн багийнхан

Альфа үеийнхэн Монгол төсөл

Альфа үеийнхэн Монгол төсөл нь 3 жилийн турш үргэлжлэх ADRA Монгол Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй халдварт бус өвчлөлөөс сэргийлэх эрүүл мэндийн туршилтийн төсөл юм. Тус төслийг хэрэгжүүлэхийн тулд зөв амьдралд дадал суулгах 12 зарчмыг агуулсан аргачлалыг зорилтот бүлэг болох 12-15 насны өсвөр насныханд зориулан төлөвлөсөн байна. Уг 12 зарчимд (C)-сонголт, (E) -дасгал, (L)-шингэн, (E)-хүрээлэн буй орчин, (B)- итгэл үнэмшил, (R)-амралт, (A)-цэвэр агаар, (T)- зориг тэвчээр, (I) -тэгш шудрага байдал, (O)-өөдрөг үзэл, (N)-хоол тэжээл ба (S) - нийгмийн дэмжлэг гэсэн зарчмууд агуулагдана. Энэхүү зарчмууд нь эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэн түүнд нөлөөлөх зан төлвийг хэрэгжүүлэхэд гол суурь үндэс болно гэж үзэж байна.

Удирдлагуудын зүгээс хэлэх үг



Альфа үеийнхэн товхимлынхоо анхны дугаарыг хүргэж байгаадаа бид маш их баяртай байна. Бид Монгол улсын өсвөр үеийнхний дунд тулгамдаад буй халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулж эерэг үр дүн гаргахад зорин ажиллаж байна. Манай төслийн баг дан ганц зорилтот хүүхэд залуучуудад чиглэхээс гадна бусад үр шим хүртэгчид болох Монголын өсвөр насныхан, хамтран ажиллаж буй сургуулийн ажилтан албан хаагчид, хүүхдүүдийн эцэг эхчүүд болон тэдгээрийн асран хамгаалагч, орон нутгийн байгууллагуудад мөн мэдээ мэдээллийг хүргэж төсөл хэрэгжилтийн шат бүрт хүрч ажиллахаар зорьж байна. Ийнхүү бүх түвшинд хэрэгцээт мэдээллийг түгээн ажилаласнаар нийгэмд гарах үр дүнг хурласан сайжруулна хэмээн найдаж байна.

~ Винделл М. Маранан,
Захирлын үг

Миний бие Монгол Улсын хөгжлийн хамгийн чухал хэсэг болох өсвөр үеийнхний эрүүл мэндэд үнэтэй хувь нэмэр оруулж байгаадаа туйлын их баяртай байна. Бид энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлэн эерэг үр дүн гаргахын төлөө бүх туршлага мэдлэг бүх зүрх сэтгэлээ зориулан ажиллах болно. Үр хүүхдийнхээ гэрэлт ирээдүйн төлөө хамтдаа зүтгэхэд та бүхний оролцоо мөн маш чухал гэдгийг онцлон хэлмээр байна. Хамтдаа хичээж гэрэл гэгээг түгээцгээе.

~Б.Оргилзул
Төслийн менежер/Хүний их эмч



ТӨСЛИЙН ЗОРИОЛГО

Манай төсөл нь Монголын 12-15 насны өсвөр үеийнхнийг эрүүл амьдралын хэв маягт хэвшүүлэх, улмаар халдварт бус өвчнөөр өвчлөх эрсдэлийг бууруулахад чиглэгдэж байна. Энэхүү төслийн гол зорилго нь CELEBRATIONS гэх эрүүл амьдралын хэв маягийн дадал зуршлыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн 12 үсгийн дагуу зарчмын дагуу хэрэгжих бөгөөд үүнээс сонголт, дасгал хөдөлгөөн, зориг тэвчээр, өөдрөг үзэл, хоол тэжээл, нийгмийн дэмжлэг/сэтгэцийн эрүүл мэнд гэсэн 6 зарчмыг сонгон ажиллаж үр дүн гаргахаар зорьж байна.

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Энэхүү төсөл хэрэгжсэнээр сонгогдсон 4 сургуулийн 2000 гаруй 12-15 насны өсвөр үеийнхэн болоод тэдгээрийн асран хамгаалагч болох нийт 4000 гаруй хүнд эерэг, эрүүл зан үйлийг хэвшүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар эзэмшүүлэхийг зорино. Мөн төслийн үр дүнд хүүхэд залуучууд халдварт бус өвчний талаархи мэдлэг мэдээллийг авч тэрхүү өвчинд өртөх эрсдэлт хүчин зүйлийг бууруулах талаар мэдээлэлтэй болж зөв шийдвэрийг гарган эерэг дадад зуршлыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.



ТӨСЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Өсвөр насныхны онцлогт тохирсон зан үйл дадал зуршлыг суулган төлөвшүүлж ирээдүй хойч үедээ эрүүл амьдралын хэв маягийг бий болгоход дэмжлэг үзүүлэх аргачлалыг хэрэгжүүлэх нь тогтвортой байдлын чухал үйл явц юм. Альфа үеийнхэн халдварт бус өвчлөлөөс сэргийлэх төслөөр дан ганц хувь хүнд зөв дадал зуршлийг хэвшүүлэхээс гадна тухайн хүнээр дамжуулан эргэн тойронд зөв нөлөөллийг бий болгох нь тус төслийн хамгийн чухал зорилт билээ. Уг төслийн хүрээнд зорилтот бүлэг болох 12-15 насны өсвөр үеийнхний зан төлвийн онцлогт тохирсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын хэрэгжүүлэн ажиллах болно. Энэхүү аргачлал нь өсвөр насныханд нөлөөлөх нөлөөллийг боловсронгуй болгохын тулд хүүхдүүдээс гадна тэдний асран хамгаалагч, орон нутгийн байгууллагууд, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч болоод багш сурган хүмүүжүүлэгч нарыг хамруулан хэрэгжүүлж байгаа нь уг төслийн давуу тал болж байна. Ийнхүү бид хамтран ажилласнаар хүүхдүүдэд илүү ойлгомжтой болоод хүртээмжтэй үйл ажиллагааг хэрэгжүүлж мөн үүн дээр тулгуурлан сургалт семинарыг боловсруулж илүү олон хүүхдүүдэд хүртээх хүрээг өргөжүүлж байна. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дэлхийн бусад орнуудад хэрэгжүүлсний үндсэн дээр хийгдэж буй аргачлал бөгөөд манай оронд тус аргачлалын дагуу системтэйгээр хэрэгжсэнээр төслийн зорилтот хүүхдүүдэд илүү хүртээмжтэй болгож цаашдын хэрэгжилтэнд тогтвортой байдлыг хангах болно.

ТӨСЛИЙН НЭЭЛТ



Альфа үеийнхэн халдварт бус өвчнөөс сэргийлэх төслийн нээлтийг 2023 оны 7-р сарын 17-ны өдөр Улаанбаатар хотын Blue Sky зочид буудлын Топаз танхимд амжилттай зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагаанд АДРА ОУ-ын байгууллагын Хөтөлбөр, инноваци хариуцсан захирал Соняа Фуна, Эрүүл мэндийн хэлтсийн дарга Хосуэ Ореллана, Эрүүл мэндийн ахлах зөвлөх Шарон Тобинг, АДРА ОУ-н байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч Винделл Маранан мөн бусад холбогдох байгууллагуудын төлөөлөгч нар оролцлоо.

ТӨСЛИЙН СУРГАЛТ СЕМИНАР

Альфа үеийнхэн - Өсвөр насны хүүхдүүдийг /12-15/ Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх төслийн гарааны сургалт, семинар 2023 оны Долоодугаар сарын 18-19-ний өдрүүдэд Тэрэлжийн байгалийн цогцолбор газар Red Rock Resort-т 2 өдрийн турш болж өнгөрлөө. Тус сургалт семинарт Монголын Адвентист Чуулганы гол төлөөлөгчид, төсөл хэрэгжүүлэхээр сонгогдсон сургуулиудын захиралууд, АДРА Олон улсын байгууллагын техникийн ажилтнууд, АДРА Монгол олон улсын байгууллагын удирдлагын баг ажилтнууд оролцов. Энэхүү сургалт семинарын зорилго нь бүх оролцогч талууд төслийн гол зорилгод хэрхэн хүрэх талаар нэгдсэн ойлголттой байх явдал байлаа.



ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ



Төсөл хэрэгжих хүрээнд 4 дүүргээс 4 сургууль сонгогдсон ба үүнд Чингэлтэй дүүргийн “Тусгал” дунд сургууль (нийт суралцагсдын тоо 260), Налайх дүүргийн “Эрдмийн оргил” цогцолбор сургууль (нийт суралцагсдын тоо 1800), Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 84-р сургууль (нийт суралцагсдын тоо 6070), Сонгинохайрхан дүргийн ерөнхий боловсролын “Хөгжил” цогцолбор сургууль (нийт суралцагсдын тоо 5000) тус тус сонгогдон хамтран ажиллахаар боллоо. 2023-2024 оны хичээлийн жилд Альфа үеийнхэн төслийг эхлүүлэн

“Тусгал” сургуулийн захирал Т.Өлзийжаргал, Налайх дүүргийн “Эрдмийн Оргил” сургуулийн захирал О.Оюунтуяа нар, ADRA-гийн Монгол дахь суурин төлөөлөгч Винделл М.Маранан тэргүүтэй цаашид хамтран ажиллахаар харилцан олголцлолыг санамж бичигт гарын үсэг зурлаа. Мөн 2024-2025 хичээлийн жилд төслөө үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр “Хөгжил” цогцолбор сургуулийн захирал С.Энх-Ариун, 84-р дунд сургуулийн захирал А.Гантулга нартай төслийн баг



бүрэлдэхүүн болон АДРА МОНГОЛ-ийн суурин төлөөлөгч Винделл М.Маранан нар уулзаж цаашид хэрэгжих үйл ажиллагааны талаар ярилцаж сургуулийн орчинтой танилцлаа. Ийнхүү төсөл хэрэгжих 3 жилийн хугацаанд монголын өсвөр насныхныг амьдралын зөв хэвшлийг суулган халдварт бус өвчлөлд өртөх эрсдэлт бус хүчин зүйлийг бууруулахын төлөө хамтран ажиллаж нийгэмд эерэг зан үйлийг төлөвшүүлэхийн төлөө ажиллаж байна.

САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

ADRA Олон Улсын Байгууллага, Долоо дахь Өдрийн Адвентистуудын Ерөнхий чуулган (Эрүүл мэндийн хэлтэс), ADRA Австри, ADRA Хонг Конг санхүүжүүлэгч байгууллагууддаа чин сэтгэлээсээ талархаж байна. Тэд бүгдийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын өсвөр насныхны эрүүл мэнд болоод сайн сайханд бодитой нөлөө үр дүн үзүүлэх боломжийг бидэнд олгогдож байна.

ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛ



Манай төслийн баг хамт олон 2023 оны хичээлийн шинэ жилийн нээлтийг угтан сонгогдсон 4 сургуулийн нээлтийн үйл ажиллагаанд орон Чингэлтэй дүүргийн "Тусгал" сургуулийн захирал Т.Өлзийжаргал, Налайх дүүргийн "Эрдмийн Оргил" цогцолбор сургуулийн захирал О.Оюунтуяа,

Баянзүрх дүүргийн 84-р сургуулийн захирал А.Гантулга болон Сонгинохайрхан дүүргийн "Хөгжил" цогцолбор сургуулийн захирал С.Энх Ариун нартай уулзан цаашдын хамтын ажилдаа ур чадвар, туршлага солилцон өсвөр үеийнхнийг халдварт бус өвчнөөс сэргийлэх зан үйлд сургах төлсийг амжилттай хэрэгжүүлэн ажиллахыг хүсч, хичээлийн шинэ жилд нь амжилт хүсэн дурсгалын зүйл гардууллаа.



ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГУУД



Төслийн багийнхан өнгөрсөн 9 сарын 19-ний өдөр Долоо дахь Өдрийн Адвентист Чуулганы Эрүүл Мэндийн Хэлтэс болон тус чуулганы Залуучуудын асуудал эрхэлсэн хэлтсийн төлөөлөгчидтэй төслийн хүрээн явагдах цаашдын үйл ажиллагааны талаар уулзаж ярилцлаа. Тус уулзалтад Эрүүл мэндийн газрын дарга Ж.Пүрэвдулам, АМОС ТББ-ын захирал М.Энхбаяр, Залуучуудын газрын дарга А.Од нар оролцов. Энэхүү уулзалтаар 2023-2024 оны хичээлийн жилд сонгож авсан ерөнхий боловсролын 2 сургуульд хамтран хэрэгжүүлэх халдварт бус өвчлөлтэй холбоотой үйл ажиллагааны талаар санал солилцсон ба төслийн үндсэн зорилго болох 12-15 насны өсвөр үеийнхнийг халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулан зөв амьдралын хэвшлийг суулгахад оршиж байна.

ТӨСЛИЙН БАГИЙНХАН

Б.Оргилзул

Төслийн менежер/Төслийн туслах болон Хүний их эмч



Б.Энхжин

Төслийн туслах болон нөлөөллийн ажилтан



З.Ганчимэг

Эрүүл мэндийн мэргэжилтэн



Л.Долгор

Хяналт, үнэлгээний мэргэжилтэн



Жен Г.

Олон нийттэй харилцах ажилтан



Та бидний Facebook дахь ADRA Mongolia хуудас болон NextGen CELEBRATIONS! Mongolia - "Альфа үеийнхэн" групп нэгдэн төслийн үйл явцтай танилцаарай.

Мөн манай www.adra.org.mn вэб сайтаар зочилж хамтран ажиллагч байгууллагууд болон санхүүжүүлэгч байгууллагуудын талаархи бүрэн мэдээлэл авах боломжтой. Манай төслийн багийнхан болоод сайн дурын ажилтан нар төслийн явцын талаархи мэдээллийг цаг алдалгүй хүргэх болно.